

АРГА ХЭМЖЭЭНҮҮДИЙН ТАЙЛАН

ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ

Эрүүл мэндийн сайдын 2022 оны 07-р сарын 01-ний өдрийн
А/346 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

**ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН 2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 09-НИЙ ӨДРИЙН “ХАВДРЫН ЭСРЭГ” АРГА
ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ БАТЛАХ ТУХАЙ” А/360 ДУГААР ТУШААЛЫН ХЭРЭГЖИЛТИЙН 2024 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН**

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	2023 оны хүрэх түвшин	Төсөв		Биелэлт, үр дүн	Хэрэгжилтийн хувь
			Нийт төсөвлөсөн төсөв	Зарцуулсан төсөв, эх үүсвэр		
	Зорилт 3. Хаврын урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлгийн үндэсний сүлжээг байгуулан, оношилгооны чадамжийг сайжруулах					
	“Хавдрын эрт илрүүлгийн төв”-д ажиллах эмч, эмнэлгийн мэргэжилтнийг сургаж чадавжуулах (Хүснэгт 2)	Эрт илрүүлгийн хувь нэмэгдсэн байна.			➤ 2024-2025 оны хичээлийн жилд ЭМХТ-ийн захирлын 2024 оны А/62 дугаар тушаалаар мэргэжил дээшлүүлэх сургалтад “Нойр булчирхайн хавдрын мэс засал судлал” 4 /үүнээс төрийн сангийн	

				гэрээгээр 3 буюу Орхон БОЭТ, Дархан-Уул НЭ, ХСҮТ/, “Умайн хүзүүний эс зүй” 17 /үүнээс төрийн сангийн гэрээгээр 2 буюу Өргөө АГ, Баянгол дүүргийн ЭМТ/, “Уушиг, голтын хавдрын мэс засал судлал” 2, “Хавдрын хөнгөвчлөх эмчилгээ” 2, “Ходоод нарийн гэдэсний хавдрын мэс засал судлал” 14 /үүнээс төрийн сангийн гэрээгээр 6 буюу Хэнтий НЭ, Налайх, Баянгол, Хан-Уул ЭМТ/, “Хөх, улаан хоолойн хавдрын мэс засал судлал” 11 /үүнээс төрийн сангийн гэрээгээр 1 буюу БГЭМТ, “Элэг цөсний хавдрын мэс засал судлал” 8 /үүнээс төрийн сангаар 3 буюу Сүхбаатар, Увс аймаг, Сонгинохайрхан дүүргийн НЭ/, “Эмэгтэйчүүдийн хавдрын мэс засал судлал” 11 /үүнээс төрийн сангаар 5 ЭХЭМҮТ, ЭНЭҮТ, Сүхбаатар аймгийн НЭ, Өргөө АГ, ӨМ БОЭТ, Налайх ЭМТ/, “Хавдрын хими эмчилгээний найруулга зүй” 7 /үүнээс төрийн сангийн гэрээгээр 4 буюу Хэнтий НЭ, Баянгол, Хан-Уул ЭМТ, ЭНЭҮТ/, “Хөхний хавдрын мэс засал судлал” 3 нийт 69 эмч үүнээс төрийн сангийн гэрээгээр 24 эмч элсэн суралцсан.
--	--	--	--	--

					➤ ЭМХТ-ийн захирлын 2024 оны А/12, А/84 дүгээр тушаалаар мэргэжил дээшлүүлэх сургалтад “Уушиг, голтын хавдрын мэс засал судлал” 4, “Хавдрын хөнгөвчлөх эмчилгээ” 2, “Ходоод нарийн гэдэсний хавдрын мэс засал судлал” 3, “Хөх, улаан хоолойн хавдрын мэс засал судлал” 8, “Элэг цөсний хавдрын мэс засал судлал” 2 нийт 19 эмч суралцаж мэргэжил дээшлүүлсэн.	
	Зорилт 4. Хавдрын тусламж, үйлчилгээний хүний нөөцийг чадавхжуулан, тусламж үйлчилгээг сайжруулах					
	Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудын эмч, эмнэлгийн мэргэжилтэн нарыг туяа хими эмчилгээний чиглэлээр сургах	Баруун бүсийн Туяа эмчилгээний салбарын 20 мэргэжилтнийг сургаж чадавхижуулсан байна.			➤ 2024-2025 оны хичээлийн жилд ЭМС-ын 2024 оны А/284 дүгээр тушаалаар төрөлжсөн мэргэшлийн “Хавдрын хими эмчилгээ судлал” төрөлжсөн мэргэшлийн сургалтад нийт 9 эмч элсэн суралцсан. Үүнээс улсын төсвийн санхүүжилтээр 5 буюу Дундговь, Дорноговь, Говь-Алтай аймаг, Хан-Уул дүүргийн нэгдсэн эмнэлэг, Хавдар судлалын үндэсний төвийн захиалгаар төрийн сангийн гэрээгээр суралцсан.	

					➤ ЭМС-ын 2024 оны А/194, А/349 дүгээр тушаалаар хавдрын туяа эмчилгээ судлалын эмч 2, хавдрын хими эмчилгээ судлалын эмч 11 нийт 13 эмч төрөлсөн мэргэшил эзэмшсэн. Үүнээс 4 эмч Дархан-Уул аймгийн Нэгдсэн эмнэлэг, Ховд, Өмнөговь аймгийн БОЭТ, Баянгол дүүргийн ЭМТ-ийн захиалгаар улсын төсвийн санхүүжилтээр төрийн сангийн гэрээгээр суралцсан.	
	Зорилт 6. Хорт хавдрын бүртгэл хяналтын цахим тогтолцоог бэхжүүлэх, мэдээллийн сан бүрдүүлэх					
6.1.7	Хорт хавдрын анхан шатны бүртгэлийн болон тайлангийн маягтын хөтлөлт мэдээний чанарт үнэлгээ хийх	10 нэгжид хяналт үнэлгээ хийгдсэн байна. Үнэлгээний тайлан			Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/611 дүгээр тушаалын 7 дугаар хавсралтаар батласан “Хорт хавдрыг бүртгэх, мэдээлэх журам”-д үнэлгээ хийсэн ба нийт 10 заалтаас 8 буюу 80 нь бүрэн хэрэгжсэн гэж үзсэн. Хэрэгжилт хангалтгүй 2 буюу 20 хувийг эзэлж байгаа боловч хэрэгжээгүй заалт байхгүй байна. Хорт хавдрын шинэ тохиолдлын бүртгэл хавдар судлалын тандалтын албаны мэдээлэл болон эрүүл мэндийн албан ёсны	

				статистик мэдээллээр бүртгэгдсэн тохиолдлын тоо зөрүүтэй мэдээлэгддэг. ХСТ-ийн тандалт судалгааны алба нь өвчлөлийн тохиолдлыг 1. Нас баралтын гэрчилгээгээр 2. Идэвхтэй хайлтын аргаар эд эсийн шинжилгээгээр эмнэлзүйн лабораториос авсан мэдээллийг нэмж гаргадаг тул зөрүүтэй гарах шалтгаан болж байгааг тодруулан цаашид мэдээллийн урсгал, хугацааг нэг болгож энэхүү журмыг албан ёсны статистикийн журамд нэгтгэх шаардлагатай гэсэн дүгнэлтэд хүрсэн.	
--	--	--	--	---	--

**ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН 2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 09-НИЙ ӨДРИЙН “ЭРҮҮЛ ЧИЙРЭГ ЭР ХҮН” АРГА
ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ БАТЛАХ ТУХАЙ А/559 ДҮГЭЭР ТУШААЛЫН ХЭРЭГЖИЛТИЙН
2024 ОНЫ ТАЙЛАН**

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	2024 оны хүрэх түвшин	Төсөв		Биелэлт, үр дүн	Хэрэгжилтийн хувь
			Нийт төсөвлөсөн төсөв	Зарцуулсан төсөв, эх үүсвэр		
Зорилт 2. Зорилт 3. Эрэгтэйчүүдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах						
3.5	Төгсөлтийн дараах сургалтаар андрологийн төрөлжсөн мэргэшлийн эмчийг үе шаттайгаар хамруулах, сургах	Мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдсан эмчийн тоо -5		ЭМС-ын 2024 оны А/284 дүгээр тушаалаар төрөлжсөн мэргэшлийн “Эрэгтэйчүүдийн нөхөн үржихүйн эрүүл мэнд, мэс засал” сургалтад 4 үүнээс эрүүл мэндийн байгууллага /Говь Алтай аймгийн НЭ/-ын захиалгаар улсын төсвийн санхүүжилтээр 1 эмч элсэн суралцсан.		
3.9	Хөгжлийн бэрхшээлтэй хөвгүүд, эрэгтэйчүүдэд нөхөн үрхижүйн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүргэхэд хүний нөөцийг чадавхжуулах	10 эмнэлгийн мэргэжилтнийг чадавхижуулж, гарын авлагаар хангасан байна		➤ ЭМС-ын 2024 оны А/284 дүгээр тушаалаар төрөлжсөн мэргэшлийн “Бөөрний мэс засал судлал” сургалтад 13 үүнээс эрүүл мэндийн байгууллага захиалгаар улсын төсвийн санхүүжилтээр 3 /Ховд БОЭТ, Төв, Говсүмбэр аймгийн НЭ/ эмч, “Эрэгтэйчүүдийн нөхөн үржихүйн эрүүл мэнд, мэс засал” сургалтад 4 үүнээс эрүүл мэндийн байгууллагын захиалгаар улсын төсвийн санхүүжилтээр 1 /Говь Алтай аймгийн НЭ/ эмч нийт 17 /үүнээс төрийн сангаар 4/ эмч элсэн суралцсан. ➤ ЭМС-ын 2024 оны А/194, А/349 дүгээр тушаалаар “Бөөрний мэс засал судлал” сургалтад амжилттай суралцсан 9 үүнээс төрийн сангаар 2 /ЦТЭ, Ховд/ эмч төрөлжсөн мэргэшил эзэмшсэн.		

3.11.	Эрчүүдийн даавар, дотоод шүүрлийн чиглэлээр эмч, мэргэжилтэн мэргэшүүлэх сургалтанд хамруулах	10 эмнэлгийн мэргэжилтнийг чадавхижуулж, гарын авлагаар хангасан байна		2024-2025 оны хичээлийн жилд ЭМС-ын 2024 оны А/284 дүгээр тушаалаар төрөлжсөн мэргэшлийн “Эрэгтэйчүүдийн нөхөн үржихүйн эрүүл мэнд, мэс засал” сургалтад 4 үүнээс эрүүл мэндийн байгууллагын захиалгаар улсын төсвийн санхүүжилтээр 1 /Говь Алтай аймгийн НЭ/ эмч элсэн суралцсан.	
	Зорилт 4. Эрэгтэйчүүдийн эрүүл мэнд, өвчлөл нас баралтанд нөлөөлж байгаа хүчин зүйлсийг судлан суурь үзүүлэлтүүдийг тодорхойлон, бодлогын нотолгоо бий болгох				
4.3	Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн үзүүлэлт, нас баралтын шалтгаанд судалгаа хийх	Судалгааны эхний үр дүн гарч, мэдээ материал цуглуулсан байна		2023 оны 01 сарын 01-нээс 12 сарын 31-ний хооронд "Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн үзүүлэлт, нас баралтын шалтгаан" судалгааг хийсэн. Судалгааны үр дүнгээс: Эрүүл чийрэг эр хүн арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлэхдээ 10 000 хүн амд дараах 3 өвчлийн нас баралтийн бууруулахаар тусгасан. Үүнд зүрхний шигдээсийн шалтгаант нас баралтын суурь түвшин 2020 оны байдлаар 8.5 байгааг 2021 онд 8.0 болгохоор зорьсон боловч 10,000 хүн амд 10.5 байна. Элэгний хорт хавдрын 2021 оны зорилтот түвшин 5.2 боловч 5.8 нас баралт бүртгэгдсэн байна. Үүнээс дүгнэхэд 2021 болон 2022 оны байдлаар нас баралт нэмэгдэж зорилтот түвшиндээ хүрээгүй байна.	

“ЭРҮҮЛ ЧИЙРЭГ ЭР ХҮН” АРГА ХЭМЖЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

(“Эрүүл чийрэг эр хүн” арга хэмжээний үр нөлөө, үр дүнг дараах шалгуур үзүүлэлтээр дүгнэх бөгөөд 2019, 2020 оны мэдээллийг суурь үзүүлэлт болгон ашиглана)

Хоёрдугаар хавсралт

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин		Хүрсэн түвшин		Хүрсэн түвшин	Дүгнэлт
				2021	2022	2022	2023.4	2024.10	
Нас баралтын үзүүлэлт /эрэгтэйчүүд/									
2	Зүрхний шигдээс өвчний шалтгаалсан нас баралтын түвшин /10000 хүн амд/	10 000 хүн амд	8.5	8	7.5	9.3	3.0	5.7	Жилийн эцсийн тайлан нэгтгэж үзүүлэлтийн ном гарсаны дараа тавигдана
	Элэгний хорт хавдраас шалтгаалсан нас баралтын түвшин /10000 хүн амд	10 000 хүн амд	5.5	5.2	4.8	5.7	1.9	4.1	

	Осол гэмтэл, гадны шалтгааны улмаас нас барсан тохиолдол /10000 хүн амд	10 000 хүн амд	13.5	13.3	12.8	16.6	4.4	7.8	
--	---	----------------	------	------	------	------	-----	-----	--

Тайлбар: Мэдээллийн эх үүсвэр

Халдварт бус өвчин, осол гэмтэлийн шалтгаан, эрсдэлт хүчин зүйлийн тархалтын үнэдсний IY судалгаа 2019 он
Эрүүл мэндийн үзүүлэлт, Хавдар судлалын үндэсний төвийн статистик үзүүлэлт 2020 он
Эрүүл мэндийн статистикийн мэдээлэл 2020
Эрүүл мэндийн мэдээлэл, сарын мэдээлэл, 2020 он

**ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН 2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРИЙН “ХАРШЛААС СЭРГИЙЛЭХ”
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ БАТЛАХ ТУХАЙ А/816 ДУГААР ТУШААЛЫН
ХЭРЭГЖИЛТИЙН 2024 ОНЫ ТАЙЛАН**

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	2024 оны хүрэх түвшин	Төсөв		Биелэлт, үр дүн	Хэрэгжил-тийн хувь
			Нийт төсөвлөсөн төсөв	Зарцуулсан төсөв, эх үүсвэр		
	Зорилго: Харшлын эрсдэлт хүчин зүйлийг бууруулан, урьдчилан сэргийлэлт, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах замаар харшлын шалтгаант өвчлөл, түүний хүндрэлийг бууруулах					
	Үйл ажиллагааны чиглэл 1.3. Харшлын өвчтэй эмнэлгийн тусламж үйлчилгээг хүртээмжтэй, чанартай болгохд чиглэсэн бодлого, эрх зүйн орчин бүрдүүлэх					
1.3.3	Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, аймаг дүүргийн нэгдсэн эмнэлэг, БОЭТ-ийн эмнэлзүйн харшил судлалын эмчийг орон тоогоор ажиллуулах	Эмнэл зүйн харшил судлалын эмчийг орон тоогоор ажиллуулсан байна.		➤ 2024-2025 оны хичээлийн жилд “Эмнэл зүйн харшил судлал” төрөлжсөн мэргэшлийн сургалтад 5, үүнээс улсын төсвийн зардлаар байгууллагын захиалгаар 4 /ДУ, ЗА аймгийн НЭ, Чингэлтэй БГ дүүргийн ЭМТ/ эмч элсэн суралцаж байна. ➤ ЭМС-ын 2024 оны А/349 дүгээр тушаалаар төрөлжсөн мэргэшлийн “Эмнэл зүйн харшил судлал” сургалтад улсын төсвийн зардлаар байгууллагын захиалгаар 2 /БХ, ГА аймгийн НЭ/ эмч амжилттай суралцаж төрөлжсөн мэргэшил эзэмшсэн.		
1.3.4.	Өрх хүүхэд чих, хамар хоолой, нүд, дотор судлалын үндсэн мэргэшлийн сургалтын хөтөлбөрт харшил судлалын хичээлийн агуулгыг шинэчлэн тусгах	Хөтөлбөрийн үр дүнг үнэлсэн байна.		Харшил судлалын хичээлийн агуулгыг доорхи үндсэн мэргэшлийн сургалтын шинэчилсэн хөтөлбөрүүдэд шинээр тусгасан. Үүнд: 1. Хүүхэд судлал - 2 долоо хоногийн тойролт 2. Өрхийн анагаах ухаан судлал - 4 долоо хоногийн тойролт 3. Дотрын анагаах судлал- Амьсгалын эрхтэн		

				тогтолцооны агуулгад Харшлын ринит, Астма сэдэв тусгагдсан байна. Дээрхи үндсэн мэргэшлийн сургалтын хөтөлбөрүүд нь 2022 онд “Үр дүнд суурилсан” сургалтын жишиг хөтөлбөрөөр шинэчлэгдсэн боловсруулж батлагдсан байдаг. Төгсөлтийн дараах үндсэн мэргэшлийн сургалт эрхэлдэг ЭХЭМҮТ, АШУҮИС, ЭНЭҮТ, УНТЭ, УХТЭ, УГТЭ-үүд батлагдсан хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж сургалтаа явуулж байна.		
	Үйл ажиллагааны чиглэл 3.2. Харшил, харшлын өвчний эмчилгээний менежментийг сайжруулах эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн чадавхийг бэхжүүлэх					
3.2.4	Харшлын шалтгаант өвчлөлийн цахим сургалтын модуль боловсруулах	Цахим сургалтыг үзэж, багц цаг бүртгүүлсэн эмнэлгийн мэргэжилтнүүд нэмэгдсэн байна.			Цахим сургалтын модуль боловсруулагдаагүй.	Төлөвлөгөөнд тусгагдаагүй
3.2.6	Өрх, сумын эрүүл мэндийн төвийн эмч нарыг харшлын өвчний цогц менежментийн сургалтад хамруулах	Сумын эрүүл мэндийн төвийн эмч нарыг сургасан байна.			Монголын харшил судлалын нийгэмлэг, АШУҮИС-ийн Уушги, харшил судлалын тэнхимтэй хамтран Хүүхдийн харшлын өвчнийг оношлох, эмчлэх, урьдчилан сэргийлэх орчин үеийн аргуудад хүүхэд, өрх, арьс, харшлын мэргэжлийн эмч нарыг сурган, хүүхдийн харшлын өвчний хяналтыг сайжруулах зорилгоор олон улсын симпозиумыг зохион байгуулахад хамтран ажилласан. Сургалтад өрх, сумын хүүхдийн өрхийн, арьс харшлын нийт 53 эмч нарыг хамруулж 1 багц цаг олгосон.	
	Үйл ажиллагааны чиглэл 4.2. Харшлын өвчлөлийн мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх					
4.2.1	Харшлын өвчлөлийг бүртгэж, мэдээлж байгаа өнөөгийн байдлыг үнэлэх				2024 онд ЭМХТ-өөс Эрүүл мэндийн салбарын статистик бүртгэл, тайлангийн маягт, журмын хэрэгжилтэд үнэлгээ хийсэн ба уг үнэлгээний 5-р бүлэгт хүн амын	

					өвчлөл, нас баралтын мэдээллийн чанарыг үнэлсэн. Уг үнэлгээгээр харшлийн өвчлөлийг ICD 10-ийн дагуу кодлон мэдээлж буй хэдий ч өвчлөлийн цаашдын эмчилгээ, сэргийлэлтэд шаардлагатай дүн шинжилгээ, бодлогын шийдвэр гаргахад шаардлагатай мэдээлэл болох өвчний шалтгаан, үүсгэгчийн мэдээлэл ихэнх бүртгэлд гарах боломжгүй, мөн бүртгэх шаардлагатай мэдээллийг дутуу бөглөсөн зэрэг нь цаашид өвчлөлийн бүртгэл мэдээллийн тогтолцоог сайжруулах, бүртгэл, мэдээлэл хариуцсан ажилтнууд төдийгүй мэдээлж буй эмч, мэргэжилтнүүдийг сургах шаардлагатай бөгөөд цаашилбал өвчлөлийн байдалд нарийвчилсан дүн шинжилгээ хийхэд зарим мэдээлэл дутмаг байгаа тул бүртгэл, мэдээллийн тогтолцоог сайжруулж, чанаржуулах шаардлагатай байна гэсэн дүгнэлт гарсан.	
4.2.2	Харшлын өвчлөлийг бүртгэл, статистик мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгох	Шинэчлэгдсэн маягтын дагуу программ хангамжид өөрчлөлт орсон байна.			Эрүүл мэндийн бүртгэл, тайлангийн үйл ажиллагаа, маягтын загварыг батлан гаргасан ЭМС-ын 2019 оны А/611 дүгээр тушаалд нэмэлт өөрчлөлт оруулж батлуулахаар ажиллаж байна. Анхан шатны бүртгэлийн маягтыг цахим хэлбэрт оруулж ашиглахад	

					өгөгдлийг дахин давтаж оруулахгүй байх, цаг хугацааг хэмнэж сонголтоор шууд сонгох хэлбэрээр бөглөх, тайлангийн маягтыг бодит цаг хугацаанд улирал, сараас үл хамааран нэгтгэж ашиглах боломжийг бүрдүүлсэн. Бүртгэлийн нийт 273 маягтыг 111 маягтад одоогийн байдлаар нэгтгэн оруулж мэдээллийн давхардлыг арилгасан ба өвчлөлийн шалтгааныг бүртгэн мэдээлэх боломжийг бүрдүүлсэн.	
--	--	--	--	--	--	--

**ЖЕНДЕРТ СУУРИЛСАН БОЛОН ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ, СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ
ТӨЛӨВЛӨГӨӨ
2024-2027 он
Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/111 дүгээр тушаал**

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хэрэгжих хугацаа, арга хэмжээ			Биелэлтийн тайлан, 2024 оны эхний 10 сар
		Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	2024 он	
ЗОРИЛТ 1. Жендерт суурилсан болон гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн, өртсөн байж болзошгүй хүнийг илрүүлэх, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэх эмч, мэргэжилтний мэдлэг, ур чадварыг дүүшлүүлэх:					
3.9.	Анхан шатны туслмж үйлчилгээн үзүүлдэг эмнэлгийн мэргэжилтэнд хүчирхийлэлд өртсөн, өртөж болзошгүй тохиолдлыг таньж мэдэх, илрүүлэх,	Бэлтгэгдсэн албан хаагчдын тоо	150 хүн	1 дүүрэг, хангайн бүсийн 8 аймгийн анхан шатны эрүүл мэндийн байгууллагын ажилчдад сургалт явуулна.	Монголын эх барих эмэгтэйчүүдийн эмч нарын нийгэмлэгээс ДЭМБ болон олон улсын удирдамжийн дагуу бэлгийн хүчирхийлэлд өртсөн хохирогч нарт эмнэлгийн анхан шатны тусламжийг үзүүлэх, дахин давтагдахаас сэргийлэх, аюулгүй байдлыг хангах, холбон зуучлах гм олон талт оролцооны талаар мэдлэг хандлага, ур чадвар олгох 5 өдрийн 3 багц цагийн сургалтыг зохион байгуулахад сургалтын хөтөлбөрийг хянаж баталгаажуулан хамтран ажиллалаа.

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хэрэгжих хугацаа, арга хэмжээ			Биелэлтийн тайлан, 2024 оны эхний 10 сар
		Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	2024 он	
	яаралтай болон анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх ур чадвар эзэмшүүлэх				Сургалтад НҮБХАС-аас хэрэгжиж буй төсөлд хамрагдсан 10 аймгийн 20 сум, Улаанбаатар хотын 2 дүүргийн эрүүл мэндийн төвийн нийт 40 гаруй эмч, эх баригч, сувилагч нар хамрагдсан.
3.12	Эрүүл мэндийн боловсрол олгох их, дээд сургуулиудын төгсөлтийн өмнөх болон төгсөлтийн дараах сургалтын хөтөлбөрт жендерийн ойлголт, жендерт суурилсан хүчирхийллийн хохирогчид үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний удирдамжийг тусгах	Тусгагдсан хөтөлбөрийн тоо	-	Төгсөлтийн өмнөх болон дараах сургалтын хөтөлбөрт үнэлгээ хийнэ.	ЭМС-ын 2021 оны А/774 дүгээр тушаалаар Төгсөлтийн дараах Үндсэн мэргэшлийн сургалтын хөтөлбөрийг “Чадамжид суурилсан хөтөлбөр” болгон шинэчлэн боловсруулах ажлыг зохион байгуулж 2022 онд 35 чиглэлээр батлагдсан. Дээрх хөтөлбөрүүдэд 2025-2026 онуудад үнэлгээ хийхээр төлөвлөж байна. ЭМС-ын 2024 оны А/111 дүгээр тушаалаар батлагдсан “Жендерт суурилсан болон гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг хангах зорилгоор 2024 онд батлагдсан Дүрс оношилгоо, Нүүр амны гажиг засал судлалын үндсэн мэргэшлийн сургалтын хөтөлбөрийн агуулгад Жендерт суурилсан болон гэр бүлийн хүчирхийлэлд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, жендерийн тэгш байдалтай холбоотой хууль эрх зүйн агуулгыг тусгасан.

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН 2021 ОНЫ А/780 дугаар тушаал
“ЭРҮҮЛ, ИДЭВХТЭЙ АМЬДРАЛ” 2021-2024 ОНЫ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Зорилго: Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дэмжиж, иргэн бүрт эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг төлөвшүүлэх

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Бүтээгдэ хүүн	2024 оны хүрэх түвшин	Төсөв		Биелэлт, үр дүн	Хэрэгжи л-тийн хувь
				Нийт төсөвлөсө н төсөв			
Зорилт 1. Эрүүл, идэвхтэй амьдралыг дэмжсэн тогтолцооны чиглэлээр бодлого, эрх зүйн орчинг сайжруулах;							
ЗОРИЛТ 5. СЭТГЭЦ, ЗАН ҮЙЛ, ТАНИН МЭДЭХҮЙН ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖСЭН НИЙГМИЙН ОРЧИНГ БҮРДҮҮЛЭХ							
76.	Сэтгэцийн, мэдрэл, донтолтын тусламж үйлчилгээний нэгдсэн хөтөлбөр хэрэгжүүлэх, сургалтыг онлайнаар явуулах бэлтгэл ажил хийх, сургалт явуулах		Сургалтыг орон нутагт бүсчлэн зохион байгуулсан байна.		<u>Мэргэшүүлэх сургалтаар:</u> ➤ ЭМС-ын 2024 оны А/284 дүгээр тушаалаар төрөлжсөн мэргэшлийн “Донтолт судлал” сургалтад 9, үүнээс улсын төсвийн зардлаар байгууллагын захиалгаар 1 /БУ НЭ/ эмч, “Сэтгэл засал судлал” сургалтад 16, үүнээс улсын төсвийн зардлаар байгууллагын захиалгаар 1 /СБЭМТ/ эмч, нийт 25 эмч элсэн суралцаж байна. ➤ ЭМС-ын 2024 оны А/349 дүгээр тушаалаар төрөлжсөн мэргэшлийн “Донтолт судлал” сургалтад 5, “Сэтгэл засал судлал” сургалтад 7 үүнээс улсын төсвийн зардлаар байгууллагын захиалгаар 2 /ТӨНЭ, СБНЭ/ нийт 12 эмч амжилттай суралцаж төрөлжсөн мэргэшил эзэмшсэн. Богино хугцааны сургалтаар:		

					Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвөөс ДЭМБ, ЭМЯ-ны дэмжлэгтэйгээр Монгол Улсад анхан шатны болон эмнэлгийн мэргэшсэн тусламж, үйлчилгээ үзүүлж буй эрүүл мэндийн мэргэжилтнүүдийн чадавхыг бэхжүүлэх сэтгэц, мэдрэл болон донтолтын (СМД) нөхцөл байдал сургалтыг 2022-2023 онд үе шаттайгаар зохион байгуулсан. 2024 оны эхний улиралд Улаанбаатар хотод зохион байгуулагдсан “Сэтгэц, мэдрэл, донтолт (СМД)-ын тусламж үйлчилгээний чадавхыг бэхжүүлэх” сургалтын үр дүнг үнэлэх зорилгоор өрхийн эмнэлгүүд, эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагаатай газар дээр нь болон цахимаар холбогдон танилцаж, үнэлгээ хийх үйл ажиллагааны календарчилсан төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна. Тус сургалтыг Дорноговь, Увс, Завхан аймаг болон Сонгинохайрхан дүүргийн нийт 210 эмч, эмнэлгийн мэргэжилтэн нарт тус бүр 5 өдрийн сургалтыг танхимаар зохион байгуулан сургалтад хамрагдсан оролцогч нарт 2.5 кредит багц цаг олгосон.	
--	--	--	--	--	--	--

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН 2022 ОНЫ 10 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРИЙН “ХАЛДВАРТ ӨВЧИНТЭЙ ТЭМЦЭХ, СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ 2022-2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ БАТЛАХ ТУХАЙ” А/528 ДУГААР ТУШААЛЫН ХЭРЭГЖИЛТИЙН 2024 ОНЫ ТАЙЛАН

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	2024 оны хүрэх түвшин	Төсөв		Биелэлт, үр дүн	Хэрэг жил-тийн хувь
			Нийт төсөвлөсөн төсөв	Зарцуулсан төсөв, эх үүсвэр		
	Зорилго. Эрүүл мэндийн аюулгүй байдлыг хангах ирээдүйн сорилтыг даван туулах арга замыг тодорхойлоход олон салбарын оролцоог хангах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тандалт, хяналт тавих нэгдсэн тогтолцоог бэхжүүлэх, нийгмийн эрүүл мэндийн					
	Зорилт 1. Эрүүл мэндийн аюулгүй байдалд нөлөөлөх шинэ сорилт, болзошгүй цар тахал, нийгтийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн хариу арга хэмжээний бэлэн байдлын чадавхыг нэмэгдүүлэх, халдварт өвчний тандалт, хяналтын тогтолцоог бэхжүүлэх					
Үйл ажиллагааны чиглэл 1.4. Талбарын тархвар судлалын хөтөлбөрийг өргөжүүлж, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн хариу арга хэмжээнд дайчлагдан ажиллах мэргэшсэн хүний нөөцийг бэлтгэж чадавхижуулах	2. АШУҮИС-ийн Нийгмийн эрүүл мэндийн магистрийн хөтөлбөрийн багц цагт Талбарын тархвар судлал сургалтын цөм хөтөлбөрийн багц багийг оруулж тооцуулах	НЭМ-ийн магистрийн сургалтад Талбарын тархвар сургалтын багц цагийг зүйцүүлэх асуудлыг судалж, холбогдох байгууллагад хүргүүлсэн байна.			Төгсөлтийн өмнөх сургалтын хөтөлбөрийн агуулга тул Манай чиг үүрэгт хамааралгүй	
	4. Талбарын тархвар зүйн чиглэлээр тасралтгүй сургалт зохион байгуулах	Сургалтыг 2 удаа зохион байгуулж, 30 мэргэжилтэн сургасан байна. сургалтын үнэлгээ хийсэн байна.		➤ 2024-2025 оны хичээлийн жилийн намрын элсэлтээр төрөлжсөн мэргэшлийн “Талбарын тархвар судлал” төрөлжсөн мэргэшлийн 1 жилийн сургалтад 10 мэргэжилтэн элсэн суралцаж байна. Үүнээс улсын төсвийн		

				зардлаар төрийн сангийн гэрээгээр 7 /Увс, Булган, Хэнтий, Төв аймгийн НЭ, Өвөрхангай БОЭТ, ХӨСҮТ, ЗӨСҮТ/ эмч байгууллагын захиалгатай байна. ➤ ЭМС-ын 2023 оны А/381 дүгээр тушаалаар төрөлжсөн мэргэшлийн “Талбарын тархвар судлал” төрөлжсөн мэргэшлийн 1 жилийн сургалтад элсэн суралцсан 7 мэргэжилтэн амжилттай төгссөн. ➤ ЭМХТ-ийн Захирлын 2024 оны А/03 дугаар тушаалаар “Талбарын тархвар судлал” төрөлжсөн мэргэшлийн сургалтын үйл ажиллагаанд явцын хяналт үнэлгээ хийж, ЭМЯ-ны дэргэдэх ЭМХЗ-ийн 2024 оны 01 дүгээр тогтоолоор сургалт эрхлэх зөвшөөрлийн хугацааг 2 жилээр сунгасан.	
	5. Талбарын тархвар судлал -Лабораторийн чиглэлээр мэргэшүүлэх сургалт зохион байгуулах	Сургалтыг 1 удаа зохион байгуулж, 10 мэргэжилтэн сургасан байна.		<u>ЛАБОРАТОРИЙН ЧИГЛЭЛЭЭР:</u> Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/125 дугаар тушаалаар Эрүүл мэндийн ажилтны төгсөлтийн дараах сургалтад 2024-2025 оны хичээлийн жилд Эмнэл зүйн эмгэг судлалаар 29 их эмчийг сургахаар хяналтын тоо батлагдсаны 10 нь улсын төсвийн санхүүжилтээр суралцуулахаар төлөвлөсөний дагуу 2024 оны элсэлтээр Лабораторийн чиглэлээр үндсэн мэргэшлийн сургалтад 29 суралцагч элссэний 6 нь улсын төсвийн санхүүжилтээр суралцаж байна. <u>ТАЛБАРЫН ТАРХВАР СУДЛАЛ:</u>	

				“Талбарын тархвар судлал-Лаборатори” төрөлжсөн мэргэшлийн сургалтын хөтөлбөрийг ЭМЯ-ны НЭМГ, ХӨСҮТ, АШУҮИС-ийн БАС, ДЭМБ-ын төлөөлөл хамтран боловсруулж, ЭМЯ-ны Вирус, нян судлалын МСЗ-өөр батлагдсан хөтөлбөрийг хянаж, ЭМХТ-ийн захирлын 2024 оны 1087 албан тоотоор ЭМХЗ-ийн хурлаар хэлэлцүүлэхээр ЭМЯ-нд хүргүүлсэн.	
	6. Талбарын тархвар судлал сургалтад дадлага удирдах сургагч багш бэлтгэх	Анхан шат болон лабораторийн сургалтын дадлага удирдах 15 сургагч багш бэлтгэсэн байна.		Төвийн захирлын 2024.04-ний өдрийн 240 дугаартай албан бичгээр Эмнэлзүйн сургагч багшаар бэлтгэх эмч, сувилагч эх баригчийн дэлгэрэнгүй судалгааг авч нэгтгэхэд 34 байгууллагаас 346 эмч, 19 байгууллагаас 80 сувилагч, 9 байгууллагаас 19 эх баригчийг сургахаар ирүүлсэн байна. Ирүүлсэн захиалгад талбарын тархвар судлалын төрөлжсөн мэргэшлийн сургалт эрхлэх байгууллага болох ХӨСҮТ, ЗӨСҮТ-өөс эмнэл зүйн сургагч багш бэлтгэх сургалтад хамрагдах шалгуур хангасан 15, анхан шатны эрүүл мэндийн байгууллагаас сургалтад хамруулахаар 82 эмч, мэргэжилтний захиалгыг ирүүлснийг Эмнэл зүйн сургагч багш бэлтгэх сургалтад хамруулахаар төлөвлөлтөд тусгасан байгаа. Сургалт 11-12-р саруудад зохион байгуулагдана.	
Үйл ажиллагааны чиглэл 2.3. Дархлаажуулалт бүхий халдварт өвчний тандалт, хариу арга хэмжээний чадавхийг сайжруулах	8. Мэргэшүүлэх сургалтыг тасралтгүй зохион байгуулах	Вакцинаторын төрөлжсөн мэргэшлийн сургалтыг хөтөлбөрийн дагуу жил 2 удаа зохион байгуулсан байна		Төгсөлтийн дараах төрөлжсөн мэргэшлийн “Дархлаажуулалтын сувилахуй”-н төрөлжсөн мэргэшлийн сургалтад нийт 127 сувилагч, эмнэлгийн бусад мэргэжилтэнг хүлээн авч ХӨСҮТ-д хуваарилан суралцуулсан. Үүнээс 59 мэргэжилтэн нь улсын төсвийн санхүүжилтээр суралцсан.	

Үйл ажиллагааны чиглэл 4.1.БЗДХ, ХДХВ, ДОХ-ын вирусын халдвараас сэргийлэх, оношилгоо, тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах эрх зүйн орчныг боловсронгуй болгох	6. Хүний нөөцийн төлөвлөлт сургалтын нэгдсэн бодлоготой болох	БЗДХ, ХДХВ, ДОХ-ын тусламж, үйлчилгээний чиглэлээр Хүний нөөцийн хөгжлийн нэгдсэн төлөвлөгөөг хэрэгжүүлсэн байна.		ХӨСҮТ-өөс Глобаль сангийн ДОХ, сүрьеэгийн төслийн дэмжлэгтэйгээр БЗДХ, ХДХВ, ДОХ-ын тусламж, үйлчилгээний чиглэлээр хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлох судалгааны дүнг үндэслэн, хүний нөөцийн хөгжлийн нэгдсэн төлөвлөгөө боловсруулахаар хүлээгдэж байна. Одоогоор хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлох судалгаа хийх багийн сонгон шалгаруулалт явагдаж, судалгаа хийгдэж байна.	
	7. БЗДХ, ХДХВ, ДОХ-ын тусламж, үйлчилгээний зааврыг боловсруулах	-		Манай албаны чиг үүрэгт байхгүй тул энэхүү ажил хамааралгүй.	
Үйл ажиллагааны чиглэл 5.3. Нутагшимал болон зөөвөрлөгдөн ор ирэх эрсдэл бүхий зоонозын халдварт өвчнийн хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангах	3. Зоонозын өвчний хариу арга хэмжээний талаар эрүүл мэндийн ажилтны чадавхжуулах	Төлөвлөгөөний дагуу сургалт зохион байгуулсан байна.		Нутагшимал болон зөөвөрлөгдөн орж ирэх эрсдэл бүхий зоонозын халдварт өвчний хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангах чиглэлээр хилийн боомтод Зоонозын алба байгуулах ажил түр хойшилсонтой холбоотой сургалтад хамрагдах хүний нөөц тодорхойгүй учраас боомтод ажиллах хүний нөөцийг чадавхижуулах зохион байгуулагдах сургалт түр хойшилсон.	
Үйл ажиллагааны чиглэл 7.1. ЭМБ-уудын халдвараас сэргийлэх, хянах тогтолцоог бүх түвшинд бэхжүүлж хүний нөөцийг чадавхжуулах	2. ЭМБ-ын ажилтныг халдвар сэргийлэлт, хяналтын чиглэлээр мэргэшүүлэх сургалтад хамруулах	Халдварын сэргийлэлт, хяналтын мэргэжлийн индекстэй болж, сургэшүүлэх сургалтыг жилд 2 удаа зохион байгуулсан байна.		➤ 2024-2025 оны хичээлийн жилийн намрын элсэлтээр төрөлжсөн мэргэшлийн “Талбарын тархвар судлал” төрөлжсөн мэргэшлийн 1 жилийн сургалтад 10 мэргэжилтэн элсэн суралцаж байна. Үүнээс улсын төсвийн зардлаар төрийн сангийн гэрээгээр 7 /Увс, Булган, Хэнтий, Төв аймгийн НЭ, Өвөрхангай БОЭТ, ХӨСҮТ, ЗӨСҮТ/ эмч байгууллагын захиалгатай байна.	

				➤ ЭМС-ын 2023 оны А/381 дүгээр тушаалаар төрөлжсөн мэргэшлийн “Талбарын тархвар судлал” төрөлжсөн мэргэшлийн 1 жилийн сургалтад элсэн суралцсан 7 мэргэжилтэн амжилттай төгссөн.	
--	--	--	--	---	--

**ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН 2021 ОНЫ 10 ДУГААР САРЫН 14-НИЙ ӨДРИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН
ЖЕНДЭРИЙН БОДЛОГЫГ 2021-2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ 2024 он**

Зорилго: Эрүүл мэндийн салбарын бүх түвшинд ажиллагсдын жендэрийн боловсролыг дээшлүүлж, эмэгтэй, эрэгтэйчүүдийн биологийн болон нийгмийн ялгаатай хэрэгцээ, нөхцөл байдлыг тооцсон, үйлчлүүлэгч болон үйлчилгээ үзүүлэгчдэд ээлтэй жендэрийн мэдрэмжтэй бодлого, бүтэц, үйлчилгээний орчин бүрдүүлж, хөгжүүлэх

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Бүтээгдэхүүн	2024 оны хүрэх түвшин	Төсөв		Биелэлт, үр дүн	Хэрэгжилтийн хувь
				Нийт төсөвлөсөн төсөв	Зарцуулсан төсөв, эх үүсвэр		
Зорилт 1. Эрүүл мэндийн салбарт ажиллагсдын жендэрийн мэдлэг, хандлага, чадавхыг дээшлүүлэн мэргэшүүлж, жендэрийн мэдрэмжтэй бодлогыг хэрэгжүүлэх;							
1.	2.2.1.1. Эрүүл мэндийн удирдах ажилтнууд болон бүх шатны үйлчилгээ үзүүлэгч ажилтнуудын сургалтын хөтөлбөрт жендэрийн асуудлыг тусгах, шийдвэр гаргагчдын дэмжлэгт орчин бий болгох, хүний нөөцийн чадавх бүрдүүлэх талаар олон улсын байгууллагуудтай болон бусад доноруудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх;	Эрүүл мэндийн салбарын бүх төрлийн мэргэжил олгох, дээшлүүлэх болон удирдах ажилтны сургалтын хөтөлбөрт жендэрийн сэдэв тусгах	Шинэчлэгдсэн сургалтын хөтөлбөрийн тоо, үйл ажиллагааны тайлан гарсан байна			-	
Зорилт:2 Жендэрийн мэдрэмжгэй төлөвлөлт, нөөц хуваарилалт, шийдвэр гаргахад хүйсээр ангилсан бүртгэл, мэдээлэл, судалгаанд үндэслэдэг болгох;							

